

ШИНЭЧЛЭЛИЙН ҮЕИЙН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ

CHANGING POLICE OFFICERS THOUGHTS IN THE PERIOD OF RENOVATION



Б.БАЯНМӨНХ ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч

BAYANMUNKH B. Assistant professor of Faculty of Police Law, Police institute, Law Enforcement university, Police major

Товч агуулга: Шинэчлэлийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим нь авилга, ашиг сонирголоос ангид байх, мэдээллийн ил тод байдлыг хангасан, иргэндээ ээлтэй үйлчилгээ үзүүлж ажиллах явдал юм.

Цагдаагийн байгууллагын шинэчлэл нь нийгмийн захиалга гэж би үздэг. Цагдаагийн байгууллага нийгмийн хөгжлийн зүй тогтлоо дагаж өөрчлөгдөх ёстой. Өөрчлөгдөж, шинэчлэгдэж байж энэ байгууллагын үйл ажиллагаа түүхийн тавцангаас арчигдах бус, харин ч нийгмийг дэвшилтэд хөгжлийн тэр хэмжээнд хүрч үйл ажиллагаагаа явуулах учиртай гэж бодож байна. Энэ үүднээс шинэчлэлд цагдаагийн алба хаагчдын сэтгэлгээний өөрчлөлт чухал ач холбогдолтой болох талаар энэхүү өгүүллээр илэрхийлэхийг хичээлээ.

Abstract: Main principle of police organs' activities in the period of renovation are being free of corruption and private interests, providing good services to community. I consider that police organs' renovation is social order. I think, if the police organs changed it wouldn't appear of historical arena and would conduct better activities.

So I'm trying to express how significant of police officer thoughts in the period of renovation by this article.

Дэлхийн алдарт Стэнфорд Их Сургуулийн сэтгэл судлаач Carol Dweck гэж сэтгэлгээ буюу итгэлийн талаар их судалсан хүн байдаг. Тэрээр бидний азгүйтэл (мөн амжилт) биднийг хэн вэ? гэдгийг тодорхойлдог сэтгэлгээг Төрөлхийн сэтгэлгээ, харин өөрсдийгөө өсөж, дэвших боломжуудаас азгүйтлийг олж харж, суралцдаг сэтгэлгээг Өсөлтийн сэтгэлгээ гэнэ хэмээн тодорхойлсон бөгөөд сэтгэлгээний өөрчлөлтийн талаар маш олон зүйл ярьж, хэлж бичиж, нийтлүүлсэн хүн юм.

Carol Dweck “Бид яаж алхаж сурсантай адил бид амьдралынхаа замд олон саад бэрхшээлтэй учирдаг. Гэхдээ бид амжилтандаа хүрч, хүссэн амьдралаараа амьдарч чаддаг. Энэ нь маш их дадлага туршлага, шургуу зан шаарддаг. Хүн ямар бодолтой байх тал дээрээ үргэлж сонголт хийдэг. Сонголт хийхэд хэзээ ч оройтохгүй” гэж хэлсэн байдаг.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын алба хаагчдын сэтгэлгээний өөрчлөлтийг хийхийн тулд шинэчлэлийн бодлогыг цогц байдлаар хэрэгжүүлэх

үе шаттай хөтөлбөр, төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх чадварлаг менежерүүдэс бүрдсэн баг шаардлагатай байна.

Цагдаагийн алба хаагчийн хувь хүний хөгжилд, гаднах имиджээс илүү дотоод төлөвшил чухал юм. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчид юу сурсан нь чухал биш яаж өөрийгөө хөгжүүлдэг нь чухал. Мөн хууль сахиулах чиглэлийн ямар ажил хийж байгаа нь чухал биш, юуг хэрхэн хийж байгаа нь чухал гэдгийг алба хаагчдад сайтар ухамсарлуулан ойлгуулах нь чухал болоод байна. Өөрчлөлт жижиг зүйлээс, хөгжил дотроосоо эхэлдэг.

Хүн ер нь нэг хийсэнээ улиг болтол давтвал өөр дүнд хүрэхгүй, шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй. Цагдаагийн байгууллага дан ганц хууль сахиулах үйл ажиллагааны бодлого, чиглэлээ өөрчлөөд хуучин арга барилаараа ажилбал энэ нь өөрчлөлт биш гэж үзэж болно.

Арга барилаа өөрчлөх хэрэгтэй ч дан ганц арга барилаа өөрчлөөд хуучин бодлогоороо ажлаад байвал бас өөрчлөлт биш, үр ашигтай ажиллаж чадахгүй. Тиймээс бодлогоо өөрчлөх хэрэгтэй.

¹ <http://mlctraining.mn/>

Дан ганц бодлогоо өөрчлөхөөс гадна түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц байхгүй бол бодлого хэрэгжихгүй.

Тиймээс бүтцээ өөрчлөх хэрэгтэй. Бүтцээ өөрчлөөд хүнээ хөгжүүлээгүй бол бүтэц оновчтой байж чадахгүй. Тиймээс хүнээ хөгжүүлэх хэрэгтэй. Дан ганц хүнээ хөгжүүлээд орчинг нь бүрдүүлээгүй бол хүний нөөцөө ашиглаж чадахгүй.

Тиймээс хүнээ хөгжүүлэхээс гадна үйл ажиллагаа, арга барил, бодлого, бүтэц, орчинг хамтад нь өөрчлөх хэрэгтэй. Өөрчлөлт эерэг, хөгжил цогц байх ёстой юм.

Өнөөдөр хууль зүйн салбарыг шинэчлэх, өөрчлөх гэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэхүү санаачлагад хуульч залуус нэгдэж эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын дэмжлэгтэйгээр боловсруулаад хэрэгжүүлэх шатандаа явж байна.

Цагдаагийн байгууллагын шинэчлэлд хамгийн чухал хүчин зүйл бол үзэл баримтлал байна. Тэрхүү үзэл баримтлалдаа нийт иргэд, ард түмнийг хэр итгүүлж, үнэмшүүлж чадна, тэр хэмжээгээр шинэчлэлийн үйл явц тогтвортой оршин тогтнож, үр дүнд хүрнэ. Гагцхүү цагдаагийн байгууллагын шинэчлэлийн ямар үзэл баримтлалтай байх вэ, ирээдүйд юу хийх вэ, яаж бусдыг араасаа дагуулах вэ гэдгийг сайн бодож хийх ёстой.

Би 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчмуудад чиглэсэн үзэл баримтлал чухал гэж боддог. Тэр нь юу вэ гэхээр, өнөөгийн бидний социал демократ үзэлд суурилсан нийгмийн ардчилсан үзэл юм. Үүнийг хүмүүст маш зөвөөр таниулж, итгүүлэх ёстой.

Цагдаагийн байгууллагын үзэл баримтлалд нийтийн ашиг сонирхол, нийтийн сайн сайхан, хүний тэгш эрх, шударга ёс гээд чухал зарчим, үнэт зүйл байдаг учраас нийгмийн ардчилсан үзлийг итгэл үнэмшлээ болгох нь чухал. Тиймээс нийгмийн ардчилсан үзэлд нэгдэж, үүний төлөө явах хүмүүстэй бид шинэчлэлийг хамтарч хийх ёстой.

Өнөөдөр цагдаагийн байгууллага дотор шинэчлэлийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөггүй нэг хэсэг байна. Юуны түрүүнд шинэчлэлийн үзэл баримтлал, бодлогыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсээс бид ангижрах, эсхүл сэтгэлгээнд өөрчлөлт хийж, шинэчлэлийн үйл явцад татан оруулах шаардлагатай байна. Эдгээр хүмүүс нь шинэчлэлийн үйл явцыг сааруулж зогсоох, улмаар сөргөөр нөлөөлөх боломжтой учраас урьдчилан сэргийлж, дээрхи алхамыг хийх ёстой.

Түүнчлэн цагдаагийн байгууллагад шинэчлэлийг хийхэд хүлээж авах алба хаагчдын сэтгэл зүй их чухал байдаг нь энэ байгууллагад хийж байгаа шинэчлэлийн үйл явцаас харж болно.

Цагдаагийн байгууллагын шинэчлэлд тулгарч

байгаа нэг том асуудал бол хуучин тогтолцоо, сэтгэлгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн алба хаагчдын сэтгэлгээг өөрчлөх явдал юм.

Шинэчлэлийн бодлого цагдаагийн байгууллага дээр эрчимтэй явагдаж байгаа бөгөөд энэ байгууллагын хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн орчинг тодорхой үе шаттайгаар шинэчлэгдэж, зорилго, чиглэлээ тодорхойлоод хэрэгжүүлэх үйл явц тодорхой хэмжээгээр явагдаж байна. Түүнчлэн алба хаагчдынхаа үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай дүрэмт хувцасны загварыг бий болгоод удахгүй алба хаагчдаа хангаад ажиллаж байна.

Тэгвэл өнөөдөр цагдаагийн алба хаагчдын сэтгэлгээг яаж хуучин тогтолцооноос нь өөрчилж, эрх зүйн шинэтгэлийн бодлоготой уялдуулан хүний эрхийг дээдэлсэн хууль сахиулах үйл ажиллагаа явуулах сэтгэхүйг төлөвшүүлэх, үүнийг хэрхэн ямар арга замаар хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Иргэндээ хүрч үйлчлэх, шуурхай, чанартай үйлчилгээг үзүүлэхэд ёс зүйтэй цагдаагийн мэргэшсэн алба хаагч нийгэмд чухал хэрэгцээтэй байна.

Үүнийг хэрэгжүүлэхэд бид алба хаагч бүрийнхээ зан араншин буюу темперамент²энд тохирсон аргыг ашиглан сэтгэлгээний өөрчлөлтийг хийж болно гэж судлаачийн хувьд үзэж байна.

Тэгвэл энэхүү сэтгэлгээний өөрчлөлтийг хийхэд бүтээлч сэтгэлгээ маш их шаардлагатай байна.

“Ирээдүйг урьдчилан хэлэх шилдэг арга бол түүнийг бүтээх явдал юм” Роберт Тинер хэлсэн байдаг.

Бүтээлчээр сэтгэн шинэ сэдлүүд үүсгэсний үр дүнд дэлхий дээрх бүх дэвшилттэй эд зүйлс, технологи, менежмент, тээвэр холбоо гээд л тоо томшгүй олон зүйл буй болсон. Шинэ нээлт хийх, санаачлага гаргахын гол арга зам нь бүтээлч байдал юм. Бүх талаараа асар хурдан өөрчлөгдөж байгаа дэлхий дээр урьдынхаасаа илүүтэйгээр бүтээлч байхыг шаардаж байна.

Хүмүүс өөрсдийн амьдралаа хөнгөн, аятайхан, аюулгүй, эрүүл, сонирхолтой болгохын тулд тасралтгүй шинэ шинэ зүйлийг бүтээсээр ирсэн бөгөөд үргэлжлүүлэн бүтээсээр байгаа билээ. Үүнийг л бүтээлч сэтгэлгээ гэж хэлж болно.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын шинэчлэлд хүний нөөцийн бодлого хамгийн чухал. Цагдаагийн байгууллага шинэчлэлийг оюун ухаандаа маш сайн тунгаасан бодолтой, тэр бодлоо сайн уншиж, хийж чаддаг хүнтэй байх хэрэгтэй. Ийм байж

² Зан араншин буюу темперамент — хүний мэдрэлийн эсүүдийн хурд, хүч, харьцаанаас хамааран төрөлхийн шинжтэй илрэх ааш зангийн хэв шинж. Холерик, сангвиник, флегматик, меланхолик хэмээн дөрвөн шинж байх бөгөөд бүгд өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Б.Батсайхан., М.Дэлгэржав. Сэтгэл судлалын үндэс. УБ. 2013. 176 дахь тал

чадвал шинэчлэл дардан замаар явна. Цагдаагийн байгууллагын шинэчлэлд хүнтэй холбоотой зүйл олон бий. Тэгэхээр энэ болгоныг л бид даван туулах ёстой.

Иргэд цагдаагийн алба хаагчдыг хуулиар далайлгасан дээрэнгүй зантай гэж шүүмжилдэг. Цагдаагийн байгууллагын бүх үйл ажиллагаанд ийм үзэгдэл байна уу гэвэл үгүй юм. Чухам юунаас болж ингэж харагдаж байна гэхээр энэ байгууллага дотор хууль зөрчдөг, ёс зүйгүй бусармаг зүйл хийдэг, ашиг сонирхлын зөрчилтэй зарим хүмүүсийн л үйлдэл цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байгаагийн илрэл юм. Энэ бүхнийг өөрчлөх хэрэгтэй.

Бид залуусынхаа шинэлэг сэтгэлгээний хүчинд тулгуурлах ёстой бөгөөд гагцхүү залуус маань зөв хөдлөх хэрэгтэй юм. Өнөөдөр шинэчлэгчид маань албан тушаалын хойноос хөөцөлдөөд эхэлбэл бүх зүйл буруу болно. Тиймээс аль болох хувийн ашиг сонирхол, албан тушаал, эд хөрөнгөнөөс ангид хийж чадвал чухал алхам болно. Бид их олон зүйлийг тэвчиж байж сайн сайханд хүрнэ. Энэ чинь л сэтгэлгээний маш том шинэчлэл юм.

Өнөөдөр улс төрчид “Гүржийн шинэчлэл” гэж их ярьдаг. Тэгвэл энэхүү шинэчлэлийн үйл явцын зарим хэсгээс авч үзье.

Гүржийн ерөнхийлөгч Михиал Саакашвили шинэчлэлийг хэрэгжүүлэхийн тулд ажиллах хүчинд маш их өөрчлөлт хийсэн байна. Тодруулбал, яам агентлагийн ажилчдыг бүгдийг нь мэргэжлийн ур чадварын болон онолын үндэслэлтэй сэтгэлгээний тест авч ярилцлага хийж тэнцсэн хүмүүсийг ажилд нь үлдээсэн бөгөөд үлдсэн ажиллах хүчийг хувийн сектор болон оюутны ширээнээс шалгаруулж авчсан байна.

Ийм өөрчлөлтийн дараа Дотоод явдлын яам 75 мянгаас 27 мянган албан хаагчтай болж цөөрсөн байна.

Тэд шинэчлэлийг хийхийн тулд сэтгэлгээний шинэчлэлд анхаарлаа онцгой хандуулсан байна. Үүний тулд бараг бүх салбартаа хувийн секторуудыг оруулж, шинэ менежмент нэвтрүүлжээ. Хувьчлал эхлэхийн өмнө Эдийн засаг хөгжлийн сайд Каха Бендукидзе “Ухамсараасаа бусдыг худалдана” хэмээн шуугиулсан. Тэр хэлсэн аманд хүрч төрийн мэдлийн зочид буудлаас эхлээд стратегийн ач холбогдолтой салбарууд болох эмнэлэг, ус түгээх сүлжээ, эрчим хүч, төмөр зам, тариалангийн талбай тэр ч байтугай ойг хүртэл хувьчилсан. Ингэснээр бүх салбарт сэтгэлгээний өөрчлөлт орж хүмүүсийн асуудалд хандах өнцөг өөрчлөгджээ.

Үүний дараа шалгаж шантаажилдаг болон зөвшөөрөл өгдөг байгууллагуудын ихэнхийг нь татан буулгажээ. Ингэснээр 909 төрлийн лицензийг 137 болгосон цөөрүүлжээ. Мөн манай мэргэжлийн

хяналт дүйх байгууллага нь хувийн хэвшилд шилжсэн гэх мэт сонин шинэчлэлүүд энэ улсад бий. Засаг солигдохоос өмнө гурван км тутамд мөнгө олох зорилготой зогсдог байсан замын цагдааг татан буулгаж “Эргүүлийн цагдаа” болгосон. Мөн авлига авсан цагдаа нарыг хатуу шийтгэсэн байна.

Тодруулбал, 50 ам.долларын авлига авсан цагдаа 10 жилийн хорих ял авсан явдал байдаг байна..

Энэ мэт авлигийн хэргүүдийг зурагтаар үзүүлж “Авлига авбал ямар ч өршөөлгүй” гэх мессежийг олон нийтэд өгсөн ба авлига авч байсан хүмүүс айдас автаж байжээ.

Өндөр шалгууртай ажилд орсон төрийн албан хаагчдийн цалин 10-20 дахин нэмэгдсэн байна. Өөрчлөлтийн тухай Саакашвили “Хоёр жилийн өмнө англи хэл мэдэхгүй хүмүүст их сургуулийн диплом олгохгүй гэсэн бол намайг амьдаар минь идчих байсан биз. Харин одоо тэгж ярьж болж байна” гэсэн нь сэтгэлгээний хувьд ямар өөрчлөлт гарсныг илтгэж байна. Бүх л салбарт сэтгэлгээний шинэчлэл хийсэн бөгөөд үүний тулд төрөөс бүх зүйлийг чөлөөлж төрд зөвхөн “Бодлого тодорхойлох” ажил үлдсэн юм.

Одоо тэгвэл бид цагдаагийн байгууллагын алба хаагчдын сэтгэлгээнд яаж өөрчлөлтийг хийх бэ гэдэг асуулт хамгийн тулгамдсан асуудал болоод байна.

Тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавих нь түүнийг шийдвэрлэхээсээ дутуугүй ач холбогдолтой.

Хамгийн гол нь бид цагдаагийн алба хаагчдынхаа сэтгэлгээний өөрчлөлтийг хэрхэн ямар арга замаар богино хугацаанд хийж, үр дүнд хүргэх вэ гэдэг асуудал шинэчлэлд хамгийн тулгамдсан асуудал болоод байна.

Өнөөдөр бидэнд шинэчлэлийн сэтгэлгээний өөрчлөлтийн үйл явцаасаа үр дүн нь илүү чухал бөгөөд үр дүнд хүрэхийн тулд шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй юм. Гэтэл бидэнд бас алдаа гарах явдал гарч болно. Өөрөөр хэлбэл сэтгэлгээний өөрчлөлтийг хийх гээд баахан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулаад шаргуу ажиллаад байтал, хөрсөн дээр буух ажлаа буруу хийсэн бол бүх хүчин чармайлт талаар өнгөрнө.

Тиймээс сэтгэлгээний өөрчлөлт хийх ажлаа зөв тодорхойлж, шинэлэг, шалгарсан арга барилаар хийх хэрэгтэй юм. Гэтэл ажлаа зөв хийгээд байтал буруу замаар явсан бол буцахдаа шороо тээнэ. Тиймээс сэтгэлгээний өөрчлөлтийг зөв хийхээс гадна зөв, шалгарсан аргыг ашиглаж хийх хэрэгтэй юм.

Энэ хүрээнд алба хаагч бүр бүтээлч байх хэрэгтэй. Нэг юм хийж бүтээх гээд зүтгэтэл, шаардлагатай дэмжлэгээ авч, орчиноо бүрдүүлж чадахгүй бол ганцаараа бүхнийг хийнэ гэдэг хэцүү, харилцаа хэрэгтэй.

Сэтгэлгээний өөрчлөлт хийх гээд буруу хүмүүстэй нөхөрлөх, эсвэл өөрөө буруу хандлагаа өөрчилж чадахгүй байвал сэтгэлгээний төлөвшсөн тогтолцоо бүрдэж чадахгүй. Тиймээс сэтгэлгээний зөв хандлага

чухал. Гэтэл хандлага зөв байгаад мэдрэмжгүй нэгэн байвал зөв хүн гэж үнэлэгдэхгүй. Тиймээс мэдрэмж чухал. Өөрчлөлт мэдрэмж, хөгжил бүгд хоорондоо уялдаа холбоотой цогц асуудал юм.

Түүнээс гадна цагдаагийн алба хаагчдын сэтгэлгээний сөрөг үр дагаварыг арилгахын тулд шалтгааныг арилгах хэрэгтэй юм. Нөгөө талаараа тэдний сэтгэлгээний илрэн гарч буй гадаад хэлбэрийн өөрчлөлтөөс гадна агуулгын өөрчлөлтийг хийх шаардлагатай юм.

Үүнийг хийхэд бидэнд нэлээн олон зүйлд анхаарлаа хандуулах шаардлага бий болж байна. Энэ нь хүнийг амьтдаас ялгаж байдаг олон шинжүүдийг ашиглан сэтгэлгээний өөрчлөлт хийх ажиллагаанууд байх болно.

Бидний ухамсар, аюун санаанд шингэн, хийж буй үйлдэл хөдөлгөөн бүрд ахуй амьдралын янз бүрийн нөхцөлд илрэн гарч байдаг олон шинж чанаруудыг сэтгэцийн шинж гэнэ.

Сэтгэцийн шинж нь зан төлөв, темперамент, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж, авъяас чадвар, зоригийн процессуудыг багтаадаг байна. Эдгээрээс бид зан төлөвийг ашиглан түүний сэтгэлгээнд өөрчлөлтийг хийвэл илүү үр дүнтэй байх болно.

Зан төлөв гэдэг нь хүний хувийн онцлог, үзэл бодол, харилцаа хандлага, үйл хэрэг, түүний үйлдэл, амьдралын янз бүрийн нөхцөл, үйл явдалд хариу үзүүлэх үндэс болж байдаг бие хүний тогтвортой шинжүүдийн цогц бүрдэл юм.³

Цагдаагийн алба хаагч бүрийн зан төлөвийн судалгааг хийж, гарсан үр дүнгээр нь алба хаагчдыг бүлэглэн, бүлэг тус бүр дээр тохирсон сургалтын шинэлэг аргыг ашиглан явуулах нь үр дүнтэй байна.

Тиймээс цагдаагийн алба хаагчдын сэтгэлгээг өөрчлөх алсын хараатай бодлого боловсруулж, үүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийн бодож, төлөвлөж хоорондын уялдаа холбоог оновчтой шийдээд шинэ сэтгэлгээтэй менежерүүдээр ажлаа хийлгэвэл Гүрж шиг өөрчлөлт хийх боломж цагдаагийн байгууллагад бий.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын хуучин хэв шинжийг агуулсан сэтгэлгээнд өөрчлөлт хийхэд дараах сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлбэл үр дүн гарах болно гэж үзэж байна. Үүнд:

1. Эрх зүйн сургалт. Цагдаагийн алба хаагчдад шинэчлэлтэй холбоотой эрх зүйн боловсрол олгож, тэднийг нийгэмд үлгэр жишээ биеэ авч явах соёлтой, өдөр тутмын амьдралдаа эрх зүйн мэдлэгээ ашиглаж, хэвшүүлэх зорилготой. Хууль ёсыг сахин биелүүлэх нь цагдаагийн ажилтан хувь хүний эрх зүйн соёлын түвшингээс шалтгаалдаг.

2. Мэргэжлийн ёс зүйн чиглэлийн сургалт. Шинэчлэлтийн цагдаагийн алба хаагч ёс зүйн хэм хэмжээг сахиж, алба үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай чадваруудыг төлөвшүүлэх чиглэлээр бусад алба хаагчдын эерэг туршлагыг сурталчлах, дэлгэрүүлэх ач холбогдолтой.

3. Удирдлага зохион байгуулалттай холбоотой сургалт. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт хийх арга зүй, удирдах албан тушаалтнуудад эрх, үүрэг, заавар, журмыг ухамсарлуулах, ажилтнуудын нийгмийн асуудал, сэтгэл зүйн үндэстэй уян хатан байдлыг бий болгох чухал шаардлагатай сургалт юм. Түүнчлэн залуу ажилтнуудыг албан тушаалд томилох, мэргэжлийн сургалт, шагнал урамшууллын системтэй холбоотой асуудлыг удирдлагын түвшинд шийдвэрлэх нь алба хаагчдын сэтгэлгээний өөрчлөлтөнд чухал нөлөөтэй.

4. Удирдлагын арга барилтай холбоотой сургалт. Удирдах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагч нь өөрийгөө бусдад таниулах, үнэлэгдэх алхамуудыг /хүнд нөхцөлд байгаа ажилтан, түүний гэр бүлд тусламж үзүүлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх гэх мэт/ хийх арга зүйд суралцах, түүнчлэн өөрийгөө хөгжүүлэх, сурч боловсрох эрмэлзлэлтэй байж ажилтнуудтай бүдүүлэг харьцах, бусдын саналыг ойшоохгүй байх, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэх зэрэг удирдлагын гажуудлаас сэргийлэх чиглэлийн сургалт юм

³ Б.Батсайхан., М.Дэлгэржав. Сэтгэл судлалын үндэс. УБ. 2013. 118 дахь тал